



БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЯНЛИГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 08 сарын 04 өдөр

Дугаар А/85

Хатан суудал

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг
“Комирнэти” (BNT162b2) вакцинаар дархлаажуулах
ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.24 дэх хэсэг, 35 дугаар зүйлийн 35.6 дахь хэсэг, Дархлаажуулалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 8 дугаар зүйлийн 8.1, 11 дүгээр зүйлийн 11.1, 14 дүгээр зүйлийн 14.1, Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.23, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, Дархаажуулалтын зөвлөх хорооны 2022 оны 01 дүгээр хурлын шийдвэр, Эрүүл мэндийн сайдын 2022 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн А/373 дугаар тушаал зэргийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Пфайзер-БиоН Тех үйлдвэрийн “Комирнэти” (BNT162b2) хүүхдийн вакцинаар дархлаажуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга: Д.Нансалмаа (Эрүүл мэндийн төвийн дарга)

Гишүүдэд: Х.Уранцэцэг (Вакцинатор сувилагч)

Б.Чулуунтогтох (Хүүхдийн их эмч)

Г.Энхбаяр (Эмчлэгч эмч)

Г.Зоригт (Эх баригч бага эмч)

Б.Эрдэнэцэцэг (НЭМА)

В.Санжид (Багийн эмч)

С.Энхтэгш (Сувилагч)

Х.Нарантогтох (Ахлах сувилагч)

Р.Цэрэнбат (Үйлчлэгч)

Б.Ганбаатар (Жолооч)

2. Дархлаажуулалтыг зохион байгуулах байнгын цэгийг Эрүүл мэндийн төв дээр, явуулын цэгийг хөдөөгийн 4 багийн төв дээр тус тус зохион байгуулсугай.

642201103

3.Пфайзер-БиоН Тех үйлдвэрийн “Комирнэти” (BNT162b2) хүүхдийн вакцинаар зааврын дагуу, сайн дурын үндсэн дээр эцэг эх, асран хамгаалагчийн зөвшөөрлийг үндэслэн 5-11 настай хүүхдийг хоорондоо нэг сарын зайтай 2 тунгаар вакцинжуулах арга хэмжээг 2022 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн зохион байгуулахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

4.Ажлын хэсэгт хяналт тавьж ажиллахыг дотоод хяналтын ажилтан (Б.Чулуунтогтох)-д даалгасугай.

ДАРГА  О.МӨНХБАТ

